



ХЭНТИЙ АЙМГИЙН ДЭЛГЭРХААН СУМЫН ХЭРЛЭНБАЯН-УЛААН ТОСГОНЫ ЗАХИРАГЧИЙН ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 16 өдөр

Дугаар А/16

Хэрлэнбаян-Улаан тосгон

Ажлын тусгай горимд шилжүүлэх тухай

Монгол Улсын "Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль"-ийн 25 дугаар зүйлийн 25.1, "Гамшгаас хамгаалах тухай хууль"-ийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2018 оны "Журам батлах тухай" А/274 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг ажлын тусгай горимд шилжүүлэх, ажиллах журам"-ын 2.4, 2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль болохтой холбогдуулан төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг 2025 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 08:00 цагаас 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 08:00 цаг хүртэлх хугацаанд ажлын тусгай горимд шилжүүлсүгэй.

2. Ажлын тусгай горимд шилжүүлсэнтэй холбогдуулан албан хаагчид хөдөө орон нутаг, хол замд явахгүй байх, холбоо барих хэрэгслийг нээлттэй байлгаж шаардлагатай тохиолдолд богино болон уртасгасан цагаар ажиллахыг нийт ажилтан албан хаагчдад үүрэг болгосугай.

3. Ажлын тусгай горимд шилжсэн үед авч хэрэгжүүлэх хариу арга хэмжээг журмын хүрээнд төлөвлөн байгууллагын дарга, эрхлэгч нартай хамтран ажиллахыг Захирагчийн ажлын албаны дарга (С.Отгонбаяр)-д даалгасугай.

ЗАХИРАГЧ



Б.ЭНХЦЭЦЭГ